

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2010 оны 08 дугаар
сарын 25-ны өдөр

Дугаар 226

Улаанбаатар хот

Г “Хөгжил финанс ББСБ” ХХК-д Г
үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл
нэмж олгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, 6.2.1, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 9.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 186 дугаар тогтоолоор батлагдсан “Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журам”-ын 5.3 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Хөгжил финанс ББСБ” ХХК-д банк бус санхүүгийн төлбөрийн баталгаа гаргах болон хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх үйлчилгээний үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг тус тус нэмж олгосугай.

2. Холбогдох хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж ажиллах, тусгай зөвшөөрөл шинээр нэмж олгосонтой холбогдуулан тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хавсралтад зохих тэмдэглэгээ хийлгэж, Улсын бүртгэлийн ерөнхий газарт холбогдох тэмдэглэл хийлгэсэн гэрчилгээ, ББСБ-ын дүрмийн нотариатаар гэрчлүүлсэн хуулбарыг 2010 оны 9 дүгээр сарын 25-ны өдрийн дотор Хороонд ирүүлэхийг “Хөгжил финанс ББСБ” ХХК /Ө.Хишгээ/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Бичил санхүүгийн газар /Н.Оюунчимэг/, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Н.Удаанжаргал/-т тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН